



**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАН  
ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү журмаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хуралдуулах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хурлын бүрэн эрх, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах журам, хурлын дэг, хурлын тэмдэглэл, шийдвэрийг баталгаажуулах, хуралтай холбоотой хувьцаа эзэмшигчийн гомдлыг шийдвэрлэх зэрэг асуудлыг зохицуулна.
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагаа, ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, цаашдын төлөвлөгөөний талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ТУЗ-ийн тайланг сонсох, компанийн үйл ажиллагаатай холбоотой чухал асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах зорилготой байна.
- 1.3. Энэ хурал нь хувьцаа эзэмшигчид, даатгуулагчид, сонирхож буй хөрөнгө оруулагчид болон зохицуулах, хянах байгууллагад компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын тайлан, мэдээллийг сонсож, тэдний мэдлэг, чадвар, дадлага, туршлагын талаар үнэлэлт өгөх, хөндлөнгийн аудиторын дүгнэлтийг сонсох боломж олгоно.

**ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД БЭЛТГЭХ БОЛОН ХУРАЛ  
ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ, ХУРЛЫН ЗАР МЭДЭЭГ ХҮРГЭХ,  
БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ**

- 2.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүрийн 4 дүгээр сарын гурав дах долоо хоногт Компанийн төв байранд хуралдуулна.
- 2.2. ТУЗ нь жил бүрийн 2 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэлийг хангах тухай асуудал хэлэлцэж хуралд бэлтгэх Ажлын хэсгийг томилж, төлөвлөгөөг батална.
- 2.3. Энэ журмын 2.2-т заасан Ажлын хэсгийг компанийн гүйцэтгэх захирал удирдана. Ажлын хэсэг нь компанийн үйл ажиллагааны тайланд “Компанийн үйл ажиллагааны ил тод байдлын журам”-ын Гуравдугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн тусгаж бэлдэнэ. Энэ журмын 3.2.2-т заасан компанийн бизнес төлөвлөгөө төсвийн хэрэгжилтийн тайлан, түүнд гүйцэтгэх удирдлагын зүгээс хийсэн дүн шинжилгээг бэлдэхдээ компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг бүрэн оролцуулах бөгөөд дүн шинжилгээг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн байна. Төлөвлөгөөнд компанийн жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэх, үйл ажиллагааны үзүүлэлтэд менежментийн багийн зүгээс хийх дүн шинжилгээ /MD&A/-г хариуцан боловсруулах ажлын хэсгийг байгуулж, уг ажлын хэсгийн гишүүд нь жилийн үйл ажиллагааны тайлан болон дүн шинжилгээний аль хэсгийг хариуцан бэлтгэхийг заасан байна.
- 2.4. ТУЗ нь жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэх бөгөөд уг хурлаар дараах асуудлыг заавал хэлэлцэх бөгөөд тухайн үед шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг хэлэлцэж болно:
  - 2.4.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах;
  - 2.4.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийн хамт хэлэлцэж дүгнэлт гаргах;



- 2.4.3. Энэ журмын 3.1.2-т заасан ТУЗ-ийн тайланг хэлэлцэж батлах.
- 2.5. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах асуудлыг заавал тусгасан байна:
- 2.5.1. Хурлыг хуралдуулах газар, өдөр, цаг;
  - 2.5.2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
  - 2.5.3. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр журам;
  - 2.5.4. Хуралд бэлтгэх явцад эрх бүхий этгээдэд танилцуулах баримт бичгийн жагсаалт;
  - 2.5.5. Санал авах хуудасны агуулга;
  - 2.5.6. Хурлын дарга;
  - 2.5.7. Тооллогын комиссын дарга, гишүүд.
- 2.6. Ээлжит хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор буюу жил бүрийн 3 дугаар сарын 18-ны дотор “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү журмын хавсралт маягтаар Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлнэ. Мэдэгдэл дараах материалыг хавсаргана:
- 2.6.1. Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр;
  - 2.6.2. Хурлын талаар хувьцаа эзэмшигчдэд хүргэх зарын загвар;
  - 2.6.3. Эрх бүхий хувьцаа эзэмшигч компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан журмын дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол бичгээр ирүүлсэн саналын хуулбар;
  - 2.6.4. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, хуулбар.
- 2.7. Хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ны дотор /КТХ 60.4/ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон хувьцаа эзэмшигчдийн цахим хаягаар хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх бөгөөд, компанийн цахим хуудсанд тавьсан, Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-ийн цахим хуудсанд тавиулахаар хүргүүлсэн байна.
- 2.8. Сонирхсон хувьцаа эзэмшигч хурлын зар мэдээ, гаргах шийдвэрийн төсөл, тэдгээртэй холбогдох мэдээлэлтэй танилцах боломж олгож, хурлын бэлтгэлийг сайтар хангах, хувьцаа эзэмшигчдэд хурлаар хэлэлцэх асуудлаар саналаа боловсруулах хугацаа олгон, хуралд оролцох эрхтэй этгээдүүдийн талаар мэдээлэл өгч, хэлэлцэх асуудлын талаар бусадтайгаа санал солилцох боломж олгох зэргээр хурлын бэлтгэлийг хангах асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга удирдан зохион байгуулж, хурлыг зохион байгуулах комисс хэрэгжүүлнэ.
- 2.9. Хурлын тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй УЦК-аар дамжуулан жил бүрийн 3 дугаар сарын 25-наас өмнө хүргүүлнэ. Мөн түүнчлэн “Санал авах хуудас”-ыг хувьцаа эзэмшигчдэд дээрх мэдээллийн хамт хүргүүлнэ.
- 2.10. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зар нь дараах мэдээллийг заавал агуулсан байна:
- 2.10.1. Хурал хийх, өдөр, цаг, газар;
  - 2.10.2. Бүртгэх өдөр;
  - 2.10.3. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
  - 2.10.4. Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох бичиг баримттай танилцах журам, газар;
  - 2.10.5. Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь.
- 2.11. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх үед хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах бичиг баримтыг бүрэн бэлдсэн байна. Эдгээр баримт бичигт агуулагдсан мэдээлэл нь хувьцаа эзэмшигчид үндэслэлтэй шийдвэр гаргах боломж ойлгохуйц байхаас гадна санал хураалт явуулах журмыг багтаасан байх ёстой.



2.12. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно. /КТХ 66.9/

### ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ЗААВАЛ ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

- 3.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг заавал хэлэлцэн:
  - 3.1.1. Энэ журмын 2.3-т заасын дагуу бэлдэж, 2.4.2-т заасны дагуу ТУЗ хэлэлцэж гаргасан жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
  - 3.1.2. ТУЗ-ийн өөрийн тайлан, ТУЗ-ийн төсөв.
- 3.2. Энэ журмын 3.1.1-д заасан тайланд Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах тухай журам"-д заасан мэдээллийг багтаасан байхаас гадна дараах мэдээллийг тусгасан байх ёстой:
  - 3.2.1. Тайлангийн хугацаанд эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, зээл болон бусад хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бол энэ тухай дэлгэрэнгүй мэдээлэл;
  - 3.2.2. Эрх бүхий албан тушаалтнуудын нэгдмэл сонирхолтой этгээдтэй нь аливаа хэлцэл хийсэн бол энэ тухай мэдээлэл;
  - 3.2.3. ирэх санхүүгийн жилийн үндсэн зорилт, үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөний талаарх мэдээлэл;
  - 3.2.4. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон бусад нэмэлт мэдээлэл;
  - 3.2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хуралд мэдээлэхээр тогтоосон бусад асуудал.
- 3.3. Энэ журмын 3.1.2-т заасан тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна:
  - 3.3.1. ТУЗ-ийн ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилт;
  - 3.3.2. Компанийн засаглалын журмуудын хэрэгжилт;
  - 3.3.3. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт.

### ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗААВАЛ ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

- 4.1. Хурлыг үр дүнтэй болгох, хувьцаа эзэмшигчдийг шийдвэр гаргахад шаардлагатай бодитой мэдээллээр хангах зорилгоор шинжилгээ судалгааны болон хэвлэлийн мэдээлэл, үүний дотор компанийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан мэдээлэл, түүнд ТУЗ-ийн өгсөн тайлбарыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас өмнө дараах мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах бөгөөд хурлын зарыг нийтэд хүргэх үед бэлэн болгосон байна /КТХ 65.6 дахь заалт/:
  - 4.2.1. Энэ журмын 2.3-т заасны дагуу бэлдсэн компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
  - 4.2.2. компанийн санхүүгийн тайлан, түүнд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт болон гүйцэтгэх удирдлагын зүгээс хийсэн дүн шинжилгээ, түүний талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
  - 4.2.3. тайлангийн жилд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай мэдээлэл, тэдгээрийг компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;
  - 4.2.4. ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай асуудлыг хэлэлцэх жилийн хурал хуралдуулах үед дараах мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ:

- 4.2.4.1. ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэрийг нь дэвшүүлж байгаа этгээдийн овог нэр, компанийн ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухай мэдээлэл, түүнийг нотлох баримт, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүний алинд нь нэр дэвшүүлж байгаа болох, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 1-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн зөвшөөрөл”, 2-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсаргасан байна. Эрх бүхий ТББ-аас ТУЗ-д нэр дэвшүүлж байгаа бол удирдах дээд байгууллагын шийдвэрийг хавсаргасан байна;
- 4.2.4.2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны эдгээр нэр дэвшигчид нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон шалгуур шаардлагыг хангаж байгаа тухай дүгнэлт.
- 4.2.5. Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал;
- 4.2.6. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт;
- 4.2.7. Компанийн ТУЗ-ийн тайлан, ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагааны талаар, нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт;
- 4.2.8. Ирэх санхүүгийн жилд хэрэгжүүлэх даатгалын шинэ бүтээгдэхүүний жагсаалт, төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөө;
- 4.2.9. Компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх тохиолдолд компанийг өөрчлөн байгуулах үндэслэл, төсөл, жилийн тайлан, компанийг өөрчлөн байгуулахад оролцож буй компаниудын /нэгдэх, нийлэх тохиолдолд/ сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, аудит, үнэлгээний тайлангийн хамт;
- 4.2.10. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах тухай асуудал хэлэлцэхээр товлосон бол оруулж буй өөрчлөлтийн тухай санал уг өөрчлөлтийг оруулж буй шалтгааны тухай тайлбар;
- 4.2.11. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай асуудал хэлэлцэх бол өр үүссэн болон өрийг төлөх боломжгүй болсон шалтгаан, өрийг хувьцаагаар солихдоо нэгж хувьцааг ямар үнээр тооцож солих тухай мэдээлэл, түүний үндэслэл тооцоо;
- 4.2.12. Нэмж хувьцаа гаргах тухай асуудал хэлэлцэх бол хувьцаа нэмж гаргах замаар нэмж санхүүжилт татах зорилго, гаргах хувьцааны тоо, гаргаж санал болгох үнэ, энэхүү үнийг тогтоосон үндэслэл тооцоо, хувьцааг хаалттай хүрээнд санал болгох бол хэнд, ямар учраас санал болгож байгаа тухай болон нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлэх эсэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл;
- 4.2.13. Хувьцааг хуваах болон нэгтгэх асуудал хэлэлцэх бол шалтгаан, хувьцааг хөрвүүлэх харьцаа, түүнийг тогтоосон үндэслэл тооцоо, бутархай үлдэгдлийг худалдан авах үнэ, хөндлөнгийн үнэлгээчний дүгнэлт;
- 4.2.14. Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудал хэлэлцэх бол их хэмжээний хэлцлийн тухай танилцуулга, агуулга, уг хэлцлийг хийх болсон шалтгаан, үр дагаврын талаар ТУЗ-ийн дүгнэлт;
- 4.2.15. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудал хэлэлцэх бол уг хэлцлийн тухай танилцуулга, хэлцлийг хийх зайлшгүй шаардлагын үндэслэл, сонирхлын зөрчилтэй эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал, хэлцлийн үнийн тухай санал;
- 4.2.16. Компанийн бонд гаргах тухай асуудал хэлэлцэх бол хэдий хэмжээний бондыг ямар үнээр, ямар хугацаа, нөхцөлөр гаргахаар төлөвлөж буй тухай танилцуулга, бондын барьцаа баталгаа шаардлагатай бол түүнийг хэрхэн

- шийдвэрлэх тухай санал, худалдан авахаар урьдчилсан байдааар санал ирүүлсэн этгээд байгаа эсэх, байгаа бол саналын нөхцөл, эх үүсвэрийн тухай мэдээлэл;
- 4.2.17. ТУЗ-ийн нарийн бичгийн талаарх мэдээлэл, түүний электрон шуудангийн хаяг, утас;
- 4.2.18. Компани ашигтай ажилласан бол ашгийг компанийн эрх бүхий албан тушаалтнууд болон ажилтнуудыг урамшуулах зорилгоор шагналын санд болон хөгжлийн санд хуваарилах үндэслэл, тооцоо.

## ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ АВАХ ЖУРАМ

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй байхаар компанийн дүрэмд заасан этгээдүүд жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад бичгээр ирүүлнэ.
- 5.2. Ирүүлж буй саналд хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудлын томъёолол, уг асуудлыг хэлэлцүүлэхээр оруулж байгаа шалтгаан, уг асуудлаар гарах шийдвэртэй холбогдох мэдээлэл, санал ирүүлсэн этгээдийн нэр, хаяг зэргийг заасан байна.

## ЗУРГАА. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ, ХУРЛЫН ДЭГ

- 6.1. Хурлыг товлосон байранд товлосон өдөр, цагт хуралдуулна.
- 6.2. Хурлын бэлтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хангуулах бөгөөд хурал зохион байгуулах комисс /хурал зохион байгуулах комиссын үүргийг ТУЗ-өөс томилогдсон тооллогын комисс гүйцэтгэнэ/ бүхий л талаар туслалцаа үзүүлж гүйцэтгэх захирал хяналт тавина.
- 6.3. Хурал хуралдахын өмнөх хурлын байр, техник хэрэгсэл, ширээ сандал, санал авах хуудас, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материал, зэргийг хангалттай хэмжээгээр бүрэн бэлдсэн байна.
- 6.4. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, хуралтай холбогдох материал болон саналын хуудсыг тараан өгөх ажиллагааг хурал зохион байгуулах комиссын гишүүд хариуцан гүйцэтгэнэ.
- 6.5. Хуралд хувьцаа эзэмшигч өөрөө биечлэн оролцох эсвэл боломжгүй бол саналын хуудсаар саналаа өгөх, итгэмжлэл олгох замаар бусад этгээдээр төлөөлүүлэн оролцох боломжтой.
- 6.6. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчид, саналын хуудсаар өгсөн санал, итгэмжлэлээр оролцож буй этгээд зэргийн нийт саналыг тоолж, хурал хүчин төгөлдөр болох ирцэд хүрсэн үед тооллогын комисс хуралд хичнээн саналын эрх бүхий энгийн хувьцааг эзэмшиж байгаа хэдэн хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснийг мэдэгдэж, Хурлын ирц, хурал хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна. Нийт саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн /биеэр, итгэмжлэлээр болон саналын хуудсаар/ тохиолдолд хурлын ирц хүчин төгөлдөр болсон гэж үзэж хурлыг эхлүүлнэ. Хурлын ирц энд заасан хувьд хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хойшлуулан, дахин хуралдах өдрийг товлож, энэ тухай тэмдэглэл хөтөлсөн байна. Хурлын ирцийн талаар болон хурлыг хүчин төгөлдөр гэж үзэх эсэх тухай тооллогын комиссын тогтоол гаргаж, албажуулан, комиссын дарга гарын үсэг зурсан байна.

2032317 № 3019120961

- 6.7. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулмагц Хурал даргалж буй ТУЗ-ийн дарга хурал эхэлснийг мэдэгдэж, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулна. ТУЗ-ийн дарга эзгүй бол түүний томилсон аль нэг гишүүн удирдана. Хурлын индэрт зөвхөн хурал даргалагч сууна.
- 6.8. Хуралд ТУЗ-ийн бүх гишүүд, компанийн “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам”-д эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон бүх албан тушаалтнууд болон ТУЗ-д нэр дэвшиж байгаа бүх хүмүүс оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулна. Эдгээр хүмүүст зориулсан тусгайлсан суудал бэлдсэн байна. Хуралд ирээгүй албан тушаалтны ирээгүй шалтгааныг ТУЗ-ийн дарга танилцуулна.
- 6.9. Хурлаар хэлэлцэхээр товлосон бүх асуудлыг танилцуулж дууссаны дараа хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн асуултад холбогдох албан тушаалтан тодорхой хариулт өгнө. Хурлын явцад тодорхой хариулт өгөх боломжгүй асуултыг протоколд тэмдэглэн, хариултыг бэлдэн хэн хариуцан, хэдийд ямар хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн дарга хуралд оролцогчдод мэдэгдэнэ.
- 6.10. Асуулт хариулт дууссаны дараа хувьцаа эзэмшигчдийн санал, хүсэлтийг сонсоно. Асуулт хариулт, санал хүсэлт бүрийг хурлын протоколд дэлгэрэнгүй тэмдэглэнэ.
- 6.11. Санал хүсэлт нь өмнө нь үг хэлсэн хувьцаа эзэмшигчдийг давтсан, хэт нуршуу байгаа, хурлын дэгээр тогтоосон хугацаанаас хэтэрснээс бусад тохиолдолд саналаа бүрэн хэлэх боломж олгоно.
- 6.12. Хурал даргалагч нь өөрийн санал бодлыг тулгах, дахин дахин тасалдуулж, тайлбар хэлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн дарамт учруулахыг хориглоно.
- 6.13. Хурлаар хэлэлцэх асуудал дууссаны дараа саналын хуудсыг бүрэн хураан авч, ТУЗ-ийн хурлаас томилогдсон тооллогын комисс саналыг тоолно. ТУЗ-ийн гишүүн сонгохоос бусад асуудлыг хууль болон дүрэмд заасны дагуу саналын дийлэнх, юмуу олонхоор шийдвэрлэнэ.
- 6.14. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж, саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүсийн нэрийг тус тусад нь жагсаана. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгнө. ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар компанийн дүрэмд заасан учраас энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 6.15. Хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэхийг хориглоно. /КТХ 63.10/
- 6.16. Хурал хуралдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хурлын тэмдэглэл, шийдвэрийг албажуулан гаргаж, хурлын дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарж баталгаажуулан хадгалах бөгөөд хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон, МХБ-д хүргүүлнэ. Хурлын шийдвэрийг компанийн цахим хуудсанд тавина.

## ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.
- 7.2. Хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгасан байна:
  - 7.2.1. Хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;



- 7.2.2. Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 7.2.3. Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;
- 7.2.4. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;
- 7.2.5. Саналын хуудасны загварыг хавсаргана;
- 7.2.6. Санал гаргасан, асуулт асуусан хувьцаа эзэмшигчдийн санал, асуулт хариулт;
- 7.2.7. Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томьёолол.
- 7.3. Хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 7.4. Хурлаас гарсан шийдвэрийг санал хураах хуудсыг тоолсон тухай тооллогын комиссын шийдвэр гарсны дараа хуралд оролцогчдод сонсгоно.
- 7.5. Хурлын тэмдэглэл үнэн зөв болохыг баталгаажуулахын тулд техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно.

### **НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

- 8.1. ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай шийдвэрт тооллогын комиссын бүрэлдэхүүнийг заасан байна.
- 8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон ТУЗ-д нэр дэвшиж байгаа этгээд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 8.3. Тооллогын комисс дараах үүрэгтэй байна:
  - 8.3.1. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийг /биеэр, итгэмжлэлээр, саналын хуудсаар/ бүртгэн, ирцийг тогтоож, хуралд оролцогчид болон хурлын даргад мэдэгдсэн шийдвэр гаргах /энэ нь тооллогын комиссын тогтоол хэлбэртэй байна/;
  - 8.3.2. Тухайн хурлын хэлэлцэх асуудал бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоог хуралд оролцогчдод мэдээлнэ;
  - 8.3.3. Хуралд оролцогчдод санал өгөх эрхээ хэрэгжүүлэх талаар тайлбарлаж, санал өгөх эрхийг хангах;
  - 8.3.4. Саналын хуудсыг хүлээн авч тоолох;
  - 8.3.5. Санал хураалтын дүнг тодорхойлж, энэ тухай тэмдэглэл хөтлөн, шийдвэр гаргах /шийдвэрт тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна/;
  - 8.3.6. Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.
- 8.4. Тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.
- 8.5. Тооллогын комисс нь хурал зохион байгуулах комиссын үүргийг гүйцэтгэнэ:
  - 8.5.1. Хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд танилцуулах мэдээллийг бэлэн болгох асуудлаар гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлнэ;
  - 8.5.2. Хурлын материалыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бөглөсөн саналын хуудсыг хүлээн авах зэрэгт туслалцаа үзүүлнэ;

### **ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ, ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ**

- 9.1. Шаардлагатай тохиолдолд ТУЗ ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

- 9.2. ТУЗ-ийн 2-оос цөөнгүй хараат бус гишүүн, хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн шаардлага гаргасан бөгөөд хэлэлцүүлэхээр санал болгож байгаа асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудал бол ТУЗ ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу гаргаж, зарлан хуралдуулна.
- 9.3. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэхээр ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдэд ээлжит бус хурал хуралдуулах санал гаргасан үед ТУЗ хурлыг заавал зарлан хуралдуулах үүрэгтэй бөгөөд хурлын зар мэдээг энэ журамд заасны дагуу хүргэнэ. Харин хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээллийг хурал зарлагч болон ТУЗ, нарийн бичгийн дарга нар хамтран бэлдэж, хувьцаа эзэмшигчдэд энэ журамд заасны дагуу хүргэнэ.
- 9.4. Хурлын бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг эчнээ санал хураалтаар шийдвэрлэж болно.
- 9.5. Эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 9.6. Эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх үед эчнээ санал хураалтын зар мэдээг хурлын зар мэдээг хүргэхээр энэ журмаар тогтоосны дагуу хүргэх бөгөөд, саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийн мэйл хаягаар болон энэ журамд заасны дагуу хүргэж, санал авах эцсийн хугацааг мэдээлсэн байна.
- 9.7. Эчнээ санал хураалтын дүнг ТУЗ-өөс томилсон тооллогын комисс гаргаж, ТУЗ уг комиссын тогтоолыг үндэслэн шийдвэр гаргана.
- 9.8. Эчнээ санал хураалтын дүнгээр гаргасан шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг энэ журамд заасны дагуу баталгаажуулан хадгалж, компанийн цахим хуудсанд мэдээлнэ.

#### АРАВ. ХАРИУЦЛАГА

- 10.1. Хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, ялангуяа ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдэд заавал хүргэх мэдээллийг хүргэх, хурлыг энэ журамд заасны дагуу хуралдуулах зэрэг асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хянаж, тухай бүр холбогдох арга хэмжээ авч байна.
- 10.2. Энэ журмыг зөрчсөн тохиолдол бүрд хэн буруутайг тодорхойлж, ТУЗ-ийн шийдвэрээр хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 10.3. Компанийн тухай хууль, энэ журмыг зөрчсөнөөс Зөрчлийн тухай хуульд заасны дагуу тorgууль төлсөн бол буруутай эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр ТУЗ-ийн шийдвэрт зааж болно.